

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, “СТАР ХОЛДИНГ” ХХК НАРЫН ХООРОНД
БАЙГУУЛСАН “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ
ТУХАЙ ГЭРЭЭ”-НИЙ 2022 ОНЫ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 01 дүгээр сарын 27

д/д	№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт	Гүйцэтгэл / тайлан/	Үнэлгээ /хувь/
1	2	3	4	5
1	3.1.1	Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;	Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллахад орон нутгийн иргэд, төрийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс саад учруулсан аливаа асуудал саад бэрхшээл гараагүй болно. Иймд тухайн шатны Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэх асуудал гараагүй болно.	100%
2	3.1.2	Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;	Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт 2022 оны 06-р сарын 25-ний өдрийн 22/25 тоот албан бичгээр мэргэжилтэн боловсон хүчинг ажлын байраар хангах хүсэлт хүргүүлсэний дагуу орон нутгаас ковш болон экскаваторын оператор, туслах ажилтан, үйлчлэгч, автосамосвалын жолооч, тогооч, усан бууч зэрэг нийт 18 ажилтанг авч ажиллуулсан. Мөн Бөмбөгөр сумаас 8 хүн, Баян-овоо сумаас 10 хүнийг ажлын байраар хангаж ажилласан. Үүнээс 6 ажилтан нь өвлийн улиралд Улаанбаатар хотод ирж тус компаний салбарт хөдөлмөр эрхэлж байна.	100%
3	3.1.3	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;	Орон нутгаас ажилд авсан иргэдийг ажлын байр нь дээр сургалт явуулж дадлагажуулах, мэргэшүүлэх, ажлын байрны ХАБЭА-н аюулгүй ажиллагааг хангах сургалтыг явуулсан. Үүний үр дүнд орон нутгаас авсан ажилчид өөрийн ажлын байранд дадлагажиж чадваржиж тогтвор сууршилтай ажиллаж байна.	70%

4	3.1.4	Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах, ажлын байрны зарыг ХХҮГ-аар дамжуулан мөн олон нийтийн хэрэгсэл, цахимаар иргэдэд ил тод нээлттэй зарлах, тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах	Ажиллах хүчнийхээ 71.4% буюу 18 ажилтанг орон нутгаас авч ажиллуулсан. Үүнээс ковшийн операторчин 4, автосамосвалын жолооч 5, экскаваторын операторчин 1, туслах ажилтан 3 хүнийг ХХҮГ-азарт бүртгэлтэй иргэдээс авч 4 хүнийг авч ажиллуулсан нь ХХҮГ-ын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдийн 33,8 хувийг эзэлж байна.	100%
5	3.1.5	Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх	<p>Бөмбөгөр, Баян-Овоо сумдын уурхайн бүс нутагт амьдардаг малчин, ард иргэдэд үйл ажиллагааныхаа талаар танилцуулсан. 2022 оны 6-р сараас 2021 оны 10-р сарын хооронд уурхайн үйл ажиллагааны тайлан болон төлөвлөгөө бүс нутагт амьдардаг малчин ард иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж цаашид юунд анхааран ажиллах талаар санал солилцсон.</p> <p>-Нэг малчин айлын гэр шатсан, Компанийн зүгээс шинэ гэр авч өгөн асуудалыг шийдвэрлэсэн.</p> <p>-Иргэд, малчидаас мод тариулах санал гарсны дагуу компанийн зүгээс 300 ш Чацаргананы мод тарьж малчдад хүлээлгэн өгсөн.</p> <p>-Малчид, иргэдээс Багын төвийг засварлах санал гаргасанаас компанин зүгээс 10 сая төгрөг гарган Багын төвийг засварлаж асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>-Малчдаас сүү, мах байнга авч байсан.</p> <p>-Малчдын хүүхдийг ажилд авсан.</p> <p>-Малчидад гурвалсан гэрээгээр 10 нөхөрлөлийн гэрээ хийж өгсөн</p>	100%

6	3.1.6	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах, тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх	Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд: ТЭЗҮ, БОНБНҮ, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, ус ашиглах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл, гэх мэт	100%
7	3.1.7	Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;	Шаардлагатай үед техник тоног төхөөрөмж, хүн хүчний туслалцаа үзүүлэх тухай Гамшгийн үед хамтран ажиллах гэрээг хийгээгүй бөгөөд 2023 онд шаардлагатай гэрээг байгуулан хамтран ажиллах болно./ Манай компани зүгээс 2022 онд эрүүл мэндийн төвд хэрэгтэй байсан Фургон автомашинаар тусалсанаас гадна нэг айлын гэр шатахад шинэ гэр авч өгсөн байгаа /	100%
8	3.1.8	Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах; /Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалт/	Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах хүсэлтэнд нийт 10 нөхөрлөлийн гэрээ хийж өгсөн.	100%
9	3.1.9	Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах.	Уурхайн эзэмшлийн зам талбайн аюулгүй байдлыг ханган тэмдэг тэмдэглэгээг байршуулж аюулгүй бүсийг тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Уурхайн талбайд мэдээллийн самбар, урьдчилан сэргийлэх дохио санамж анхааруулга аюулгүй тэмдэг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.	100%
10	3.1.10	Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх,	2022 онд усны хомсдолтой байсны улмаас уул уурхайн ажил жилийн төлөвлөгөөний дагуу ажиллаж чадаагүй бөгөөд олборлосон металлыг Баянхонгор аймгийн Монгол Банкны салбарт тушааж холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.Усны газар 10 сая төгрөг нь татвар, АМНАТ нийт 72,518,725,44 татвар төлсөн.	100%

11	3.1.11	Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банкинд тушааж байх;	Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Аймгийн Голомт банкинд тушааж байсан. Метаал хайлсан газар СХЗГ 2022.09.07 /2,534.9гр/ Метаал хайлсан газар СХЗГ 2022.09.15 /1,672.8 гр/ Метаал хайлсан газар СХЗГ 2022.09.22 /1,181.74гр/ Метаал хайлсан газар СХЗГ 2022.09.23 /2,456.3гр/	100%
12	3.1.12	Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх.	Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг хангаж ажилласан.	100%
13	3.1.13	Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг сум орон нутгийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах	Орон нутгийн нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг сум орон нутгийн тулгамдаж байсан Эрүүл мэндийн газарт Фургон авто тээврийн хэрэгсэлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллассан. Багт 10 сая төгрөгний туслалцаа үзүүлэн ажиллассан.	100%
14	3.1.14	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гадна бусад зах зээлээс авахгүй байх,	- Цэлмэг Өглөө ХХК-иас барилгын материал 7,4 сая төгрөгөөр худалдан авалт хийсэн.	100%
15	3.1.14.1	Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах	Баянхонгор аймгийн Баян Баялаг өргөө ХХК 37,580 сая хүнс бараа худалдан авсан. - Орчны бүсийн иргэдээс хонь 5 сая, үхэр 8сая, адууны мах 2,5 сая төгрөгний мал мах худалдаж авсан. - 2022 оны тайлангийн жилд Баянхонгор аймгийн аж ахуйн нэгж болон хувь хүмүүсээс хүнсний бүтээгдэхүүн, бараа материал ажил үйлчилгээг авсан	100%
16	3.1.14.2	Ажлын хувцас, дээжний уутийг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах	Уурхайн ажилчдын нормын хувцасны эдэлгээний хугацаа дуусаагүй тул 2022 онд ажлын хувцас авах гэрээ байгуулах боломжгүй байсан. Ажлын хувцас эдэлгээний хугацаа дуусангуут татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авна.	100%

17	3.1.14.3	Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох	Харуул хамгаалалтын тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч Мөнхболд Жигүүр ХХК-н Шонхор хамгаалалтын газартай хамтран ажилласан.	100%
18	3.1.15	Орон нутагт төлвөл зохих татвар шимтгэл /газрын төлбөр, усны төлбөр, хог хаягдлын төлбөр/-үүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх	Ус ашигласны төлбөр 10 сая төгрөг төлсөн.	40%
19	3.1.16	Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд	Ус ашиглах тухай дүгнэлтийг "Усны Газар" ТӨААТҮГ-аас 2022 оны 06-р сарын 28-ны өдрийн 152 тоот дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг авсан бөгөөд ус ашиглах гэрээг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай 2022 оны 06-р сарын 29-нд 07 тоот гэрээг байгуулж 2022 онд ашигласан усны тооцоогоо тоолуурын заалтын дагуу баталгаажуулж орон нутгийн төсөвт усны төлбөр 10 сая төгрөг төлсөн.	100%
20	3.1.17	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх	Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлийг гаргуулан, ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулан ажилласан;	100%
Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь			92,5... хувь	

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА:  Д.МӨНХСАЙХАН

ДҮГНЭСЭН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Т.ХИШИГБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
"СТАР ХОЛДИНГ" ХХК-НИЙ
ДЭД ЗАХИРАЛ:  Х.ТОГМИД

